



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар A/318

Улаанбаатар хот

**Чингэлтэй дүүргийн 2024-2028 оны стратеги
төлөвлөгөө, дүүргийн Засаг даргын Тамгын газрын
2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Чингэлтэй дүүргийн 2024-2028 оны стратеги төлөвлөгөө, дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулан, батлуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

Ахлагч:

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын дарга
Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт,
гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хууль эрх
зүйн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү,
Төрийн сангийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
хөгжлийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хүнс,
худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Тохиржилт,
нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хяналт-
шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Агаар, орчны
бохирдолтой тэмцэх тасгийн дарга

Нарийн бичгийн
дарга:

Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт,
гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн Засаг
даргын үйл ажиллагааны хөтөлбөр
хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн гишүүдийн уялдаа холбоог хангаж, ажлыг шуурхай зохион байгуулан, 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор үр дүнг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг (Ж.Тамир) -д үүрэг болгосугай.

3. Чингэлтэй дүүргийн 2024-2028 оны стратеги төлөвлөгөө, Засаг даргын Тамгын газрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулан, батлуулахад шаардагдах

1525010969

хөрөнгийг холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ